

# Нууц үг

Компьютерын аюулгүй байдлын судалж буй нэгэн оюутан нийгмийн сүлжээний хамгаалалтыг судлах явцдаа аюулгүй байдлын томоохон зөрчлийг илрүүлжээ. Тэрээр нийгмийн сүлжээний системд нэвтрэхдээ жинхэнэ нууц үгийн дэд мөрийг агуулсан дурын тэмдэгт мөрийг нууц үг болгон оруулахад тухайн системд амжилттай нэвтэрч буйг тогтоосон. Жишээлбэл, нэвтрэх нууц үг **abc** бол **abc**, **abcd** эсвэл **cineabcma** гэсэн мөрийн аль нэгийг оруулбал системд амжилттай нэвтрэх бөгөөд харин **axbc** мөрийг оруулбал нэвтэрч чадахгүй.

Оюутан эхний хэрэглэгч системд жинхэнэ нууц үгээ ашиглан нэвтэрсний дараа хоёр дахь хэрэглэгчээр нэвтрэх боломжтой хэчнээн хос хэрэглэгчид байгааг мэдэхийг хүсэж байна. Түүнд туслана уу.

## Оролт

Оролтын эхний мөрөнд хэрэглэгчдийн тоо  $N$  ( $1 \leq N \leq 20\,000$ ) эерэг бүхэл тоог агуулна. Дараагийн  $N$  мөр бүр хэрэглэгчийн нууц үгийг агуулна. Нууц үгс нь дор хаяж нэг тэмдэгтээс тогтох ба хамгийн ихдээ 10 англи цагаан толгойн жижиг үсгээс тогтоно.

## Гаралт

Цорын ганц мөртай ба нэвтрэх боломжтой хосуудын тоог харуулна.

## Жишээ:

Оролт	Гаралт	Жишээний тайлбар
3 aaa aa abb	1	
3 x x xy	4	Эхний хэрэглэгч хоёр дахь, хоёр дахь хэрэглэгч эхний, гурав дахь хэрэглэгч эхний ба хоёр дахь хэрэглэгчээр нэвтрэх боломжтой.
5 mir mirta ta ir	6	

t

---